



Миний бие нь 1965 оны 03 дугаар сарын 25-нд тус сумын нутагт, Буджав овогтой Ширнэнжавын дөрөв дүгээр охин болж мэндэлсэн. Ингээд аав ээжийн гар дээр

өсөж ториноод, 1973 онд ерөнхий боловсролын сургуульд элсэн орж 1981 онд төгссөн. Ам бүл 4.

Мэргэжил: Улаанбаатар хотын техникумд 1981 онд элсэн орж 1984 онд "нягтлан бодогч" мэргэжлээр төгссөн.

2001 онд МУИС-ийн Эдийн засгийн салбар сургуулийн, компьютерийн мэдлэг олгох сургалтанд хамрагдан, програмуудыг судалж, амжилттай төгссөн.

Улс төр менежментийн академийг "Нийгмийн удирдлагаар" мэргэшүүлэх сургалтыг 2011 онд дүүргэсэн.

Нийгмийн хамгааллын салбарын хүрээнд нийгмийн ажлын мэргэшүүлэх сургалтанд 3 удаа хамрагдаж сертификат авсан

Ажил эрхлэлт: 1986 оны 05 дугаар сараас 1991 оны 03 дугаар сар хүртэл, Монгол банкны харъяа тус сумын тооцооны төвд нярав, нягтлан бодогчоор, 1991-ээс 1997 онд ХААН банкинд нягтлан бодогчоор ажиллаж байгаад орон тооны цомхотголоор гарсан.

Засаг даргын Тамгын газарт халамж үйлчилгээний ажилтнаар 2004 оны 09 сараас 2008 оны 03 дугаар сар хүртэл, 2008 -2011онд Иргэний бүртгэлийн ажилтан, 2011 оноос одоог хүртэл Улсын бүртгэгчээр ажиллаж байна.

Гавъяа шагнал: 2009 оны ажлаараа “Төр захиргааны шилдэг ажилтан”-аар

2011 онд “Сангийн яамны 100 жилийн ойн хүндэт тэмдэг”-ээр

2012 онд “Улсын бүртгэлийн Ерөнхий газрын жуух бичиг” –ээр

2013 онд “Төрийн шилдэг албан хаагч”

2013 онд “Завхан аймаг байгуулагдсаны 90 жилийн ойн медаль

2013 онд Завхан аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн “Оны тэргүүний ажилтан”- аар тус тус шагнагдсан. Улсад нийт 28 жил, төрийн байгуулагад 20 жил ажилласан.